

**ТАЙВАНЫ МОНГОЛЧ ЭРДЭМТЭН ЛАНЬ МЭЙХУАГИЙН БИЧСЭН
“ЦЭДЭНБАЛЫН ҮЕИЙН МОНГОЛ- ХЯТАДЫН ХАРИЛЦАА (1952-1984)
БҮТЭЭЛ
(номын шүүмж)¹**

ХЭРЭЭД Ж.УРАНГУА

МУИС-ийн Түүхийн тэнхимийн профессор

Товч агуулга: Тайваны Үндэсний Ченчи Их Сургуулийн профессор Лань Мэйхуагийн судалгааны бүтээл болох “Цэдэнбалын үеийн Гадаад Монгол², Коммунист Хятадын³ харилцаа (1952-1984)” гэсэн ном Монгол, Төвөдийн тухай нэгэн сэдэвт бүтээлийн цувралын 106 дугаарт 2000 онд Тайпей хотноо хэвлэгдэн гарсан байсныг 2019 онд Монгол Улсын Шинжлэх ухааны Академийн Олон улсын харилцааны Хүрээлэнгээс эрхлэн, хятад хэлнээс орчуулан “Цэдэнбалын үеийн Монгол, Хятадын харилцаа” хэмээн товчилсон нэрээр хэвлэн гаргаж, нийтийн хүртээл болгосон нь олон монголчууд уг бүтээлтэй танилцах боломж олгосон байна. Энэхүү өгүүлэлд тус номд шүүмж болгон бичсэн зүйлс орсон болно. Чингэхдээ Монголын орчин үеийн түүхэнд Цэдэнбалын үе гэж чухам аль үеийг хэлэх, түүний онцлог хийгээд өгүүлэн буй үеийн Монгол-Хятадын харилцааны асуудлуудыг гаднын судлаачийн нүдээр харж хэрхэн дүгнэн бичсэн аагаад тэр нь түүхэн бодит байдалд хэрхэн нийцэж байгаа талаар өгүүлэх болно.

Түлхүүр үгс: нийгэм-соёл, социалист интернационал, хөгжил дэвшил, гадаад бодлого

Удиртгал

Монголч эрдэмтэн Мей Хуа 1983 онд Тайваны Ченчи их сургуулийн (National Chengchi University) Дорно дахины хэл, соёлын ангийг дүүргэсэн ба 1988 онд тус сургуульдаа Хятадын хилийн бүс нутгийн судалгааны хүрээлэнд магистрт суралцаж, Харнууд Хаанчулуу багшид шавь орж, монгол судлалын ажлаа эхлүүлжээ. Улмаар АНУ-ын Харвардын их сургуулийн магистрантурт суралцаж, Дорнод Ази-бүс нутгийн судлалаар судалгааны ажил хийж магистрын зэрэг

¹ Тус өгүүллгийг ОХУ-ын Суурь судалгааны фонд болон Монгол Улсын БШУЯ-ны хамтарсан “Дэлхийн болон Оросын Монгол судлал: үндэсний дэг сургууль, үзэл баримтлал, судлаачид” / Монг а 20-59-4408/төслийн хүрээнд гүйцэтгэв.

² Гадаад Монгол гэдэг нь Бүгд Найрамдах Монгол Ард Улсыг хэлж буй.

³ Бүгд Найрамдах Хятад Ард улсыг хэлж буй.

хамгаалжээ. 1996 онд Харвардын Их Сургуулийн Өвөр Ази ба Алтай судлалын салбарт “Монголын тусгаар тогтнолын төлөө 1911 оны хөдөлгөөн: Нэгдсэн Монгол улс байгуулах эрмэлзэл” сэдвээр докторын зэрэг хамгаалжээ. Мейхуа өдгөө Ченчи их сургуулийн Угсаатан судлалын тэнхимд профессор бөгөөд Монголын нийгэм, соёл, монгол бичиг үсгийн судалгаа, үндэстний асуудал, бие даан суралцах чадвар эзэмших зэрэг хичээлүүд заадаг. Түүний түүх судлалын ажил 1911 оны монголчуудын тусгаар тогтнолын төлөөх тэмцэл, Монголын шинэ үеийн түүх бичлэг, Ар-Өвөр монгол угсаатны адилсал, МАХН ба Гоминдан намын харилцаа, Монгол-Төвөдийн хорооны түүх судлал зэрэг чиглэлээр явагдаж байна. Докторын зэрэг горилон бичсэн “Монголын тусгаар тогтнолын төлөө 1911 оны хөдөлгөөн: Нэгдсэн Монгол улс байгуулах эрмэлзэл” бүтээлийг нь МУИС-ийн Түүхийн тэнхимээс эрхлэн 2011 онд монгол хэлээр УБ хотноо хэвлэгдэн гарсан юм.

Харин энэ удаад яригдах “Цэдэнбалын үеийн Монгол, Хятадын харилцаа” бүтээл бол Хятадын хилийн бүс нутгийн судалгааны хүрээлэнд Мейхуагийн хамгаалсан магистрын судалгааны ажлыг бага зэрэг нэмж засварласан хувилбар юм. Тэртээ 1986 онд бичигдсэн уг бүтээл нь өдгөө судалгааны ач холбогдлоо ер алдаагүй хийгээд түүнчлэн судлаачийн тухайн цаг үеийн түүхийн талаарх ойлголт, тайлбар ямар байсныг харуулснаараа онцлогтой.

Бүтээлийн бүтэц, агуулга

Лань Мэйхуагийн туурвисан бүтээл нь Юмжаагийн Цэдэнбал БНМАУ-ын төрийн тэргүүн байх үеийн Монгол-Хятадын харилцааны асуудлуудыг хөндөн авч үзсэн нэгэн сэдэвт бүтээл нь бүтцийн хувьд 6 бүлэг, 11 зүйл, хавсралт хэсгээс бүрдсэн, нийтдээ 100 гаруй мянган ханзтай агаад Улаанбаатарт хэвлэгдэн гарахдаа 12,16 хэвлэлийн хуудас бүхий ном болон хэвлэгдэн гарчээ⁴.

Сайх бүсгүй судлаачийн энэхүү бүтээл нь Ченчи Их Сургуулийн Хятадын хилийн бүс нутгийн судалгааны хүрээлэнд 1986 онд гүйцэтгэсэн магистрын судалгааны ажил бөгөөд уг бүтээл нь 2000 онд Тайпэйд хэвлэгдэн гарсан тухай дээр дурдсан билээ. Зохиогчийн бичсэнээр, тухайн үеийн хань үндэстний үзэл суртлаас зайлсхийх үүднээс” Коммунист Хятад, Гадаад Монголын харилцааг судлах нь” гэж нэрлээгүй, харин Гадаад Монголыг субъект болгож “Гадаад Монгол, коммунист Хятадын харилцаа” гэж нэрлэн, улмаар Цэдэнбалын үеийн хэмээн тодотгожээ.

Бүтээлийн нэгдүгээр бүлэгт 1921-1952 оны хоорондох Монгол улсын хөгжил, дэвшлийн талаар зохиогч өөрийн ойлголтын хүрээнд хүүрнэн өгүүлжээ. Хоёрдугаар бүлэгт 1952-1960 оны БНМАУ ба БНХАУ-ын харилцаа хэрхэн хоёр талын санаачилга дор хэрхэн өргөжин тэлж байсан тухай бичсэн. Гуравдугаар бүлэгт 1960-1966 оны хоорондох Монгол ба Хятадын харилцааны хөгжлийг өрнөлт болон бууралттай нь авч үзэж улмаар БНХАУ болон ЗХУ-ын хоорондын зөрчилдөөн нэмэгдсэнээр Монгол-Хятадын харилцаа хэрхэн буурсан талаар авч үзжээ. Дөрөвдүгээр бүлэгт 1966-1979 оны хоёр орны харилцаанд Хятад дахь

⁴ Лань Мэйхуа. 2019. *Цэдэнбалын үеийн Монгол,Хятадын харилцаа (1952-1984)*. Орчуулсан: Дамдинсүрэнгийн Батжаргал, Алтангэрэлийн Хүрэл-Очир. Орчуулгын редактор: Намжилчойжилын Алтантөгс, Дашнямын Золбоо.Хэвлэлийн компани “ТЭПЭ”ХХК, Улаанбаатар

соёлын хувьсгал хэрхэн нөлөөлсөн талаар өгүүлжээ.Тавдугаар бүлэгт 1979-1984 оны хоорондох Монгол, Хятадын харилцаа хэрхэн сөргөлдөөний талбар болж, хоёр орны намын харилцаанд тодорхой ахиц гараагүй он жилүүд байсны тухай өгүүлжээ. Зургаадугаар бүлэгт дүгнэлтээ бичжээ.

Зохиогч судалгааны ажилдаа Ю.Цэдэнбалын үеийн Монгол, Хятадын харилцааны хөгжил ямар үе шатыг дамжсан, үе тус бүрийн онцлог, гадаад бодлогод дүн шинжилгээ хийх, олон улсын коммунист ажилчны хөдөлгөөнд хагарал гарч Зөвлөлт болон Хятад эсрэгцсэн хүчин хоёр хүчин болсон явдал Монгол-Хятадын харилцаанд хэрхэн нөлөөлсөн хийгээд эл үед БНМАУ-ын хувьд идэвхгүй гадаад бодлого явуулахаас өөр сонголт байсан уу? зэрэг асуудлуудыг хөндөн, судлаачийн хувьд өөрийн гэсэн гаргалгаа дүгнэлт гарган бичсэн маш сонирхолтой ажил амуй.

Доктор Лань Мэйхуа Монголын түүхийн 1921-1952 оны үеийг гурван үед хуваан авч үзжээ. Үүнд:

1. 1921-1928 он буюу Үндэсний ардчилсан үзэлтнүүд засаг барих үе
2. 1928-1940 он буюу Зүүнтэн ба шинэ эргэлтийн бодлогын үе
3. 1940-1952 он буюу Х.Чойбалсангийн засаглалын жилүүд хэмээн авч үзжээ.

Зохиогч ХХ зууны Монголын түүхийг 1921 оноос эхлүүлэн авч үзсэн нь социализмын үеийн Монголын түүх бичлэгт баримталж байсан үечлэлийг дагажээ.

Үндэсний ардчилсан үзэлтнүүд засаг барьж байх үед тэдний хооронд үзэл санааны зөрөлдөөн бус харин эрх мэдлийн төлөөх өрсөлдөөн өрнөж байсан хэмээн үзэж, тухайн үед өрнөсөн үйл явдлуудыг энэ үзэлтийн үүднээс тайлбарлан бичжээ. Чингэхдээ “хоёрдогч дайсантайгаа эвсэж, үндсэн дайснаа цохих” явдал бол коммунист намуудын нэгдмэл фронтын тактик юм⁵ хэмээн тодорхойлон МАН III их хурлын үеийн С.Данзан, Э.Ринчино болон Дамбадорж нарын зөрчлийн тухай бичсэн байна.

Өгүүлэн буй үед Монголын нийгэмд буй болсон цоо шинэ нөхцөл байдал нь улс орны цаашдын хөгжлийн үзэл баримтлалыг боловсруулахад олон ургалч үзэл санаа, нарийн ээдрээтэй зөрчил тэмцэл өрнөж байсан юм. Үүнд, МАН-аас “Түмэнд тунхаглан зарлах бичиг”-г дэвшүүлсэн хөгжлийн үндэсний ардчилсан үзэл баримтлалыг хамгаалсан С.Данзан нарын байр суурь, түүнтэй шууд холбоотой Ж.Цэвээний “хоршооны социализмын” тухай үзэл санаа, коммунизмд хүрэхийн тулд капиталист шатыг бүхэлд нь алгасна гэсэн Э.Ринчиногийн хэт зүүний баримтлал нарын хоорондын зөрчил байсан билээ.

Зохиогч цааш нь 1924-1952 онуудад Монголд өрнөсөн гол гол түүхэн үйл явдлуудыг тоочин өгүүлээд, төгсгөлд нь: Х.Чойбалсан 1952 оны 1 сарын 26-нд Москвад нас барснаар Монголд нэгэн шинэ үе эхлэхтэй зэрэгцэн БНХАУ-ын зүгээс Гадаад Монголыг ихэд сонирхох болж, улмаар нөлөөгөө тогтоохын төлөө ЗХУ-тай өрсөлдөж эхлэв⁶ хэмээн судалгааныхаа гол хэсэгт анхаарлаа хандуулж, судлагдахуунаа:

- 1952-1960 он Гадаад Монгол, коммунист Хятадын харилцаа идэвхтэй хөгжсөн;
- 1960-1966 он Харилцаа тодорхойгүй байдлаас хүйтрэлд шилжсэн нь;
- 1966-1979 он Харилцаан дахь зогсонги байдлын үе;

⁵ Лань Мэйхуа.2019. *Цэдэнбалын үеийн Монгол-Хятадын харилцаа (1952-1984)*.Улаанбаатар “ТЭПЭ”ХХК, тал18

⁶ Лань Мэйхуа. *Дурдсан зохиол*, тал 31

1979-1984 он Зогсонги байдлын үе хэмээн 4 шат болгон авч үзсэн байна.

Цэдэнбалын үеийн Монгол-Хятадын харилцааны түүхийг тийнхүү үечлэн авч үзэхдээ зохиогч тус хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны өсөлт бууралтыг шалгуур болгон авч үзсэн байна. Хэдийгээр тус хоёр орон социалист хамтын нөхөрлөлийн хүрээнд хамтын пролетарийн интернационализмын уриа дор хамтран ажиллах чиглэлтэй байсан боловч социалист байгуулалтын талаар санал зөрөлдөх, олон улсын ажилчны хөдөлгөөнд хагарал гаргах гэсэн хэмээн буруушаагдах, харилцан шөргөлцөх зэрэг үйл хэргүүд гарч, нэгэн хэсэг хугацаанд холдох явдал ч гарч байв. Мөн асуудлын гол нь Монголд умард болон өмнөд хөрш аль аль нь нэр нөлөөтэй байхыг ихэд эрмэлзэж, тэд өөр хоорондоо өрсөлдөж байсан явдал Монгол улсын хөгжилд мөн тодорхой нөлөөлөл үзүүлж байсан нь бодит байдал юм. Ялангуяа Хятад, Монголын харилцаанд Зөвлөлтийн нөлөө асар их байв.

Судлаач ХХ зууны БНМАУ-ыг өнгөн дээрээ тусгаар тогтносон бүрэн эрхт улс боловч газар зүйн хаагдмал нөхцөлд хавчигдсан, өмнө талд нь чоно, хойд талд нь барс архирч байдаг гэхээр, өөрөөр хэлбэл коммунист Хятад болон Зөвлөлтийн хооронд хавчигдан амь зуух төдий байсан ба бодитоор тусгаар тогтнож, өөрийн хэргээ өөрөө мэдэх явдлаа хэрэгжүүлж чадаагүй хэмээн үзжээ⁷. БНМАУ дөрвөн удаа (1946, 1948, 1955, 1956) НҮБ-д элсэх өргөдлөө цуцалтгүй өргөн барьж, эцэст нь 1961 онд элсүүлэн авсан нь нэгийн өгүүлэх амуу.

Тус бүтээлийн II-VI бүлэгт Цэдэнбалын үеийн Хятад-Монголын харилцааны асуудлуудыг судлан үзжээ. Тэрээр Цэдэнбалын засаглалын эхэн үед Монголын талаас Хятадтай харилцах харилцаа тухайд: “Гадаад Монгол нь коммунист Хятадын засгийн газар байгуулагдсаны дараа тус улстай харилцаагаа бэхжүүлж, Хятадын нөлөөллийг өөртөө бий болгох замаар Гадаад Монгол дахь Зөвлөлтийн нөлөөллийг өөртөө бий болгох замаар Гадаад Монгол дахь Зөвлөлтийн нөлөөллийг тэнцвэржүүлэх, улмаар коммунист Хятадаар дамжуулан гадаад ертөнцтэй илүү харилцахыг сонирхсон байж болох юм”⁸ гэсэн таамгийг дэвшүүлжээ. Энд би бээр зохиогчийн санааг хүндэтгэн үзэхийн зэрэгцээгээр нэгэн эргэцүүллийг дурдахыг хүсэж байна. 1946 онд Хятад улс Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрснөөс хойш Чан Кайши, Мао Цзэ Дун аль аль нь БНМАУ бол Хятадын салшгүй хэсэг мөн хэмээн үзэж байсныг монголчууд мэдэж байсан агаад мөн түүнчлэн Хятад үүнийгээ ЗХУ-аар хүлээн зөвшөөрүүлэхийг хичээж байсныг ч мэдэж байв. Ийм нөхцөлд БНМАУ-аар дамжин бусад орнуудтай харилцах тухай санаа сэдэх нь боломжгүй мэт. Нөгөө талаар Хятадын зүгээс Монголыг өөрийн нэг хэсэг хэмээн үзэж, сурталчилж байсан нь Монголын нийгэмд зарим нэгэн хүмүүс⁹ ЗХУ-тай нэгдэх тухай саналыг Цэдэнбалын үед гаргаж байсныг ч санах хэрэгтэй.

Цэдэнбалын үеийн Хятад-Монголын харилцааны онцлог байдлуудыг судлаач дараах байдлаар тодорхойлон бичжээ. 1952-1960 онуудад Монгол-Хятадын харилцаа өрнүүн хөгжсөнөөр тус оронд Зөвлөлт дангаараа ноёрхож байсныг Хятад эвдэж, өөрийн гэсэн орон зайтай болсон, Монголд коммунист Хятадыг

⁷ Лань Мэйхуа. *Дурдсан зохиол*, тал 121

⁸ Лань Мэйхуа. *Дурдсан зохиол*, тал 34

⁹ 1953 онд Сталиныг нас барсны дараа БНМАУ-ын прокурор Б.Жамбалдорж ЗХУ-д нэгдэх санал гаргасныг МАХН-ын удирдах албаны хүмүүс дэмжиж ЗХУ-д мэдэгдсэн. ЗХУ-ын эрх баригчид хэлэлцээд, зөвшөөрөөгүй.

дотночлох урсгал үүссэн. Эл байдалд Зөвлөлт дүгнэлт хийж Хятадтай өрсөн Монголд тусламж дэмжлэг олгож, Монголыг Хятадын эрхшээлд орж, Зөвлөлтийн эсрэг ашиглагдахаас сэргэмжлэн болгоомжлох болжээ.

Лань Мэйхуа, Монгол-Хятадын харилцаа муудах болсны шалтгааныг олон улсын харилцааны ээдрээтэй асуудлуудыг хөндөх замаар гарган тавьж өгсөн нь тус бүтээлийн шинэлэг тал болж байна. Энд маш олон эх сурвалжуудыг бүтээлчээр ашиглан, өөрийн оюун дүгнэлтийг гаргажээ. Тус хоёр орны харилцаа хөрж хөндийрөхөд Зөвлөлтийн бодлого ихээхэн нөлөөлсөн бөгөөд БНМАУ ч Зөвлөлтийг дагахаар шийдсэнийг дэлгэн тавьжээ. Мөн түүнчлэн Хятадад өрнөсөн “Соёлын их хувьсгал”-ын галзуурсан давалгаанд Хятад-Монголын харилцаа хэрхэн өртөн цохигдож буурсныг харуулахдаа Хятадад өрнөж байсан үйл хэргүүдийг гаргаж тавьсан нь сонирхол татна.

Хятад-Монголын харилцаа хөндийрч тасарсан үеийн түүхийг өгүүлэхдээ Зөвлөлт-Хятадын харилцааны суурь дээр авч үзсэн нь тухайн үеийн геополитикийн нөхцөл байдлыг ойлгоход ихээхэн дөхөм болох зүйл болжээ. Гэхдээ зарим нэгэн үйл явдлын дүгнэлт дээр санал зөрөх зүйл байх боловч, сайх үг бол судлаачийн үзэл бодол агаад оюун дүгнэлт учир түүнд нь хүндэтгэлтэй хандах нь шинжлэх ухааны ёс зүйн асуудал юм. Судлаач мөн: “... Монгол нь коммунист Хятадтай харилцахдаа бүгдийг бусдын тушаалын дагуу хэрэгжүүлэлгүй, зарим үед өөрийн санаачилгаар шийдвэр гаргах явдал ч байсан гэдгийг анхаарч үзэх хэрэгтэй”¹⁰ гэсэн нь түүхэн бодит байдалд бүрнээ нийцнэ. Тэрээр түүнчлэн, Монгол нь Хятадаас ажиллах хүч оруулж, хөрөнгө санхүүгийн дэмжлэг авч бүтээн байгуулалт хийж байсан нь нөгөө талаараа мөн Зөвлөлтөөс авах тусламжийг улам нэмэгдүүлэх хөшүүрэг болгон ашиглаж байжээ гэсэн дүгнэлттэй зарим талаар санал нийлж болох мэт.

Зохиогч Монгол Зөвлөлтийг дагаснаар багагүй төлөөс төлсөн гээд, үүнээс өөр арга байгаагүй, Монголд Зөвлөлтийг эсэргүүцсэн үзэлтэй хүмүүс олон байсан гэсэн дүгнэлт хийжээ.

Ингээд эцэст нь цохон тэмдэглэхэд Тайваны монголч эрдэмтэн Лань Мэйхуагийн бүтээл нь Хятад-Монголын харилцааны түүхийн нэгэн үеийг өргөн агуулгаар тавьж цаг, үе, нөхцөл байдал, дотоод, гадаад, эерэг, сөрөг хүчин зүйлсийг нягтлан тунгаасан бүтээлч санаа дүгнэлтээр баялаг, гаднын судлаачийн нүдээр харан үнэлэлт дүгнэлт өгсөн, нэн сонирхолтой бүтээл болсныг цохон тэмдэглэе.

**Written by Lan Meihua, a Mongol scholar from Taiwan,
Mongolian-Chinese relations (1952-1984)
(Book Review)**

Summary: A study by Lan Meihua, a professor at Chengchi National University in Taiwan, entitled “Outer Mongolia and Communist China Relations during the Tsendenbal Period (1952-1984)” was published in Taipei in 2000 in issue 106 of the monograph series on Mongolia and Tibet. Published by the Institute of International Relations of the Mongolian Academy of Sciences and translated from Chinese under the abbreviated title “Mongolian-Chinese Relations in the Tsendenbal Age”, it has been made available

to many Mongolians. This article contains a review of the book. Topics such as the Tsendenbal period in the modern history of Mongolia, and its features relate to the issues of Mongolian-Chinese relations were evaluated through the point of view of an independent external researcher and how they correspond to the historical reality.

Keywords: socio-culture, socialist international, development, foreign policy